

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**“Хөвсгөл шинэ мөрөн худалдааны төв” ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн
санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан.**

Аудитын код: ХӨА-2025/014/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2025 он

Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089116 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Давааням

Утас: 92113932 Цахим хаяг: davaanyam@audit.gov.mn

Гурван Хөх Морьт Аудит ХХК

Гүйцэтгэх захирал: Н.Отгончимэг

Утас: 99051815 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com

Аудитор: Ш.Саранчимэг

Утас: 99834361 Цахим хаяг: gurvankhukhmoritllc@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	5-8
3.1 Компани, түүний үйл ажиллагаа	9
3.2 Компанийн гадаад, дотоод орчин	9-10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлт	10-15
4. Аудитын тайлан	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	1-18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	18
5. Аудитын илрүүлэлт	18-20
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	21

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТЗБАХ	Техник Зохион Байгуулалтын Арга Хэмжээ
ТӨХК	Төрийн Өмчит Хувьцаат Компани



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

“ШИНЭ МӨРӨН ХУДАЛДААНЫ ТӨВ”
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Б.БАЯРМАГНАЙ ТАНАА

2025.03.14 № 1/307
танай _____-ны № _____-т

Хараат бус аудиторын дүгнэлт

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шинэ мөрөн худалдааны төв” ОНӨҮГ-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

1. Бараа материалын үлдэгдлийг биечлэн тооллого хийхэд 5 нэр төрлийн 82,630.0 мянган төгрөгийн бараа материал нь биетээр агуулахад байхгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2. "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана." Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн "Нийцсэн бөгөөд зохистой байх" "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

2. ТУЗ-ийн баталсан бизнес төлөвлөгөөнд батлагдсан тэтгэмжийн зардлыг 50,210.0 мянган төгрөгөөр хэтрүүлж, гүйцэтгэх захирлын тушаалаар 6 албан хаагчдад 19,639.2 мянган төгрөгийн тэтгэмж олгохдоо хууль эрх зүйг зөрчиж нотлох баримтыг хангалттай бүрдүүлж ажиллаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Хөдөлмөрийн дотоод журмын 9.1.4, 9.1.5, 9.1.6 гэсэн заалтуудтай нийцэхгүй Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

3. Шинэ жилийн үйл ажиллагаанд зориулж 2,500.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан. Дээрх зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "үр ашигтай байх" 12 дугаар зүйлийн 12.1.4. "хуулиар зөвшөөрөөгүй бусад" 15 дугаар зүйлийн 15.1.5. "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15 дугаар зүйлийн 15.1.7. "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах"-ыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

67022123

4. ТУЗ-ийн 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 18 дугаар тогтоолоор албан тушаалаас чөлөөлөгдсөн компанийн гүйцэтгэх захиралд 14,256.0 мянган төгрөгийн тэтгэмжийг нотлох баримтгүй, хууль эрх зүй үндэслэлгүй олгосон байна. Дээрх зөрчил нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80.1.3-т "ажилтан эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй нь эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоогдсон бөгөөд түүнийг шилжүүлэн ажиллуулах өөр ажлын байр байхгүй" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Аймгийн ИТХ, ТУЗ-ын шийдвэрээр тухайн байгууллагын харилцах дансны үлдэгдлээс 123,870.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэж, улсын төсвийн байгууллагууд, ахмадын хороодод үнэ төлбөргүй өгсөн нь дээд шатны байгууллага нь гүйцэтгэх удирдлагын эрхэнд халдсан, тухайн байгууллагын үр ашгийг бууруулсан үйлдэл болсон байна.

Аудитын гол асуудал

Аудитаар 32,103.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 5 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлсэн.

Бусад асуудлын хэсэг

ТУЗ-ын 01 дүгээр тогтоолоор 2024 оны бизнес төлөвлөгөөг 233,780.0 мянган төгрөгөөр алдагдалтай баталсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1.1.1	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	149,119,684.62	106,140,071.73
1.1.2	Дансны авлага	65,946,258.21	41,432,425.01
1.1.6	Бараа материал	26,988,362.83	103,171,674.73
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	242,054,305.66	250,744,171.48
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,362,452,137.33	5,192,084,323.79
1.2.2	Биет бус хөрөнгө	104,050,000.00	104,050,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,466,502,137.33	5,296,134,323.79
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,708,556,442.99	5,546,878,495.27
2.1.1.1	Дансны өглөг	3,934,437.41	3,023,333.01
2.1.1.2	Цалингийн өглөг	722,933.31	0.00
2.1.1.3	Татварын өр	20,282,118.18	37,170,357.88
2.1.1.4	НДШ-ийн өглөг	104,298.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	331,100.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	25,374,886.90	40,193,690.89
2.2	Өр төлбөрийн нийт дүн	25,374,886.90	40,193,690.89
2.3.1	Төрийн өмч	5,468,800,000.00	5,468,800,000.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	804,442,672.00	804,442,672.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(590,061,115.91)	(766,557,867.62)
2.3.11	Эздийн өмчийн дүн	5,683,181,556.09	5,506,684,804.38
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	5,708,556,442.99	5,546,878,495.27

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Төгрөгөөр

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1	Борлуулалтын орлого (Түрээсийн орлого)	616,166,264.44	597,439,526.32
2	Борлуулалтын өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	616,166,264.44	597,439,526.32
	Нийт зардал	690,220,045.96	753,735,028.03
10	Ерөнхий ба удирдлагын зардал	689,969,253.96	746,767,736.61
11	Санхүүгийн зардал	250,792.00	149,109.60
12	Бусад зардал	0.00	6,818,181.82
	Үйл ажиллагааны бус зардал	(9,724,053.03)	(20,201,250.00)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(9,724,053.03)	(20,201,250.00)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(83,777,834.55)	(176,496,751.71)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(83,777,834.55)	(176,496,751.71)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 01-р сарын 01-ний үлдэгдэл	5,461,000,000.00	0.00	264,242,100.00	(506,283,281.36)	5,218,958,818.64
Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	540,200,572.00	0.00	540,200,572.00

Хөвсгөл аймгийн "Шинэ мөрөн худалдааны төв" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(83,777,834.55)	(83,777,834.55)
Өмчид гарсан өөрчлөлт	7,800,000.00	0.00	0.00	0.00	7,800,000.00
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,468,800,000.00	0.00	804,442,672.00	(590,061,115.91)	5,683,181,556.09
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(176,496,751.71)	(176,496,751.71)
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	5,468,800,000.00	0.00	804,442,672.00	(766,557,867.62)	5,506,684,804.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Төгрөгөөр	
		Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	623,203,101.86	724,253,583.67
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	614,087,791.86	691,079,995.67
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.6	Бусад мөнгөн орлого	9,115,310.00	33,173,588.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	560,744,331.23	741,555,014.74
1.2.1	Ажиллагчдад төлсөн	236,618,143.90	305,378,579.60
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	53,697,093.33	67,078,645.67
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	67,820,615.00	136,908,166.18
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	137,587,385.94	154,290,014.61
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	9,500,300.00	23,714,012.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	48,774,793.06	48,922,880.68
	Даатгалын төлбөрт төлсөн	5,146,000.00	5,109,948.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	1,600,000.00	152,768.00
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	62,458,770.63	(17,301,431.07)
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	20,300,000.00	25,678,181.82
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	20,300,000.00	25,678,181.82
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(20,300,000.00)	(25,678,181.82)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	42,158,770.63	(42,979,612.89)
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	106,841,569.99	149,119,684.62
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	149,119,684.62	106,140,071.73

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	зөрүү	хувь
I	Нийт борлуулалтын орлого	578,421,000.00	597,439,526.32	(19,018,526.32)	103%
1	Худалдааны төвийн орлого	549,171,000.00	569,006,674.22	(19,835,674.32)	103%
2	50*100* Цогцолборын орлого	12,800,000.00	10,788,988.00	2,011,012.00	84%
3	Соёмбо Цогцолборын орлого	6,450,000.00	6,875,000.00	(425,000.00)	107%
4	Бусад орлого	10,000,000.00	10,768,864.00	(768,864.00)	108%
II	Нийт үйл ажиллагааны зардал	812,200,400.00	753,735,028.03	58,465,371.97	90%

Хөвсгөл аймгийн "Шинэ мөрөн худалдааны төв" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан

1	Нийт цалингийн сан	269,448,000.00	243,305,487.00	26,142,513.00	90%
2	НД-ын шимтгэл	36,376,000.00	30,824,988.67	5,551,011.33	85%
3	ТУЗ-ийн зардал	46,178,000.00	44,646,213.10	1,531,786.90	97%
4	Томилолтын зардал	12,600,000.00	5,736,000.00	6,864,000.00	46%
5	Цахилгаан эрчим хүч	96,159,000.00	60,868,619.10	35,290,380.90	63%
6	Дулаан эрчим хүчний зардал	36,800,000.00	33,014,685.91	3,785,314.09	89%
7	Цэвэрлэгээ үйлчилгээ	11,718,000.00	4,838,768.19	6,879,231.81	41%
8	Шуудан холбооны зардал	3,750,000.00	1,394,545.45	2,355,454.55	37%
9	Ариутгалын зардал	4,290,000.00	-	4,290,000.00	0
10	Бохир ус тээврийн зардал	22,820,000.00	15,752,600.00	7,067,400.00	69%
11	Хог хаягдлын зардал	4,760,000.00	2,016,136.36	2,743,863.64	42%
12	Автомашин, шатахууны зардал	12,900,000.00	17,272,727.24	(4,372,727.24)	134%
13	Бичиг хэргийн зардал	8,954,000.00	9,759,636.35	(805,636.35)	109%
14	Сургалтын зардал	1,400,000.00	2,080,000.00	(680,000.00)	149%
15	Маркетингийн зардал	4,400,400.00	-	4,400,400.00	0
16	Хөдөлмөр хамгааллын зардал	9,065,000.00	14,814,662.02	(5,749,662.02)	163%
17	Нийгмийн халамжийн зардал	12,890,000.00	63,100,430.00	(50,210,430.00)	490%
18	Самбар байрлуулсны газрын төлбөр	500,000.00	-	500,000.00	0
19	Засварын зардал	19,181,000.00	12,480,253.56	6,700,746.44	65%
20	Үндсэн хөрөнгийн элэгдэл	181,657,000.00	175,844,745.36	5,812,254.64	97%
21	Даатгалын зардал	5,146,000.00	5,109,948.00	36,052.00	99%
22	Газрын төлбөр	2,000,000.00	998,400.00	1,001,600.00	50%
23	50*100-н зардал	5,248,000.00	3,057,999.90	2,190,000.10	58%
24	Соёмбо цогцолборын зардал	3,960,000.00	-	3,960,000.00	0
25	Бусад зардал		6,818,181.82	(6,818,181.82)	0
26	Үйл ажиллагааны ашиг (алдагдал)	(233,779,400.00)	(156,295,501.71)		
27	Үйл ажиллагааны бус зардал		(20,201,250.00)	(20,201,250.00)	
28	Үндсэн хөрөнгө данснаас хассан олз (гарз)		(20,201,250.00)	(20,201,250.00)	
29	Татварын өмнөх ашиг/ алдагдал	(233,779,400.00)	(176,496,751.71)		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.3.1 Компанийн үйл ажиллагаа, зорилго зорилтын талаар

"Шинэ мөрөн худалдааны төв" ХХК-ийн эрхэм зорилго нь "Худалдаа эрхлэгч нарыг тохилог, стандартын шаардлага хангасан орчин үеийн шийдэл бүхий ажлын байраар хангахын зэрэгцээ худалдан авагчдын сэтгэлд нийцсэн хэрэгцээт барааг нэг дороос сонгон үйлчлүүлэх боломжийг бүрдүүлэхэд оршино" гэсэн байна.

Нийт 6048 метр квадрат талбайд бараа болон хүнсний павильон, задгай лангуу түрээсэлж, бүх төрлийн бараа үйлчилгээний төвлөрсөн худалдаа үйлчилгээг ард иргэддээ үзүүлж байна. Тус худалдааны төв нь дараах онцлог давуу талтай. Үүнд:

- Битүү (өвлийн улиралд дулаан, зуны улиралд сэрүүн)
- Цэвэрхэн, тохилог (орчин үеийн стандарт шаардлагад нийцсэн)
- 24 цагийн харуул хамгаалалттай
- Иж бүрэн камержуулалт хийгдсэн
- Галын аюулгүй байдал бүрэн хангагдсан
- Нийт 300 автомашины ил зогсоолтой
- Төрийн нэг цэгийн төвлөрсөн үйлчилгээтэй
- Сум хоорондын автовокзалтай
- 50/100 "Соёмбо" цогцолборуудыг хариуцан үйл ажиллагаа явуулж байна.

Худалдааны төвийн зохион байгуулалт:

1 дүгээр давхарт 6.3 метр квадрат талбай бүхий 60 ширхэг павильон, 52 метр квадрат талбай бүхий 11 ширхэг хүнсний бөөний худалдааны өрөө, Говь хангай мебель тавилгын дэлгүүр, цайны газар, үсчин гоо сайхан, гар утас түүний дагалдах хэрэгсэл, барьцаалдан зээлдүүлэх үйлчилгээ, бичиг хэрэг, гоо сайхан, ахуйн бараа, гадна талд 10 павильон, бөөний төв 2 дугаар давхарт бараа бэлэн хувцасны 172 ширхэг павильонуудтай гэрээ байгуулан ажиллаж байна. "Шинэ мөрөн худалдааны төв" ХХК-ийн гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор баталсан бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажилласан байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин.

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

"Шинэ мөрөн худалдааны төв" ХХК нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигч нь Хөвсгөл аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хурлын чөлөөт цагт компанийн эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байна.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмүү өртгийн албан татварын тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна.

ТУЗ-ийн 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн 10 дугаар тогтоолоор "Шинэ мөрөн худалдааны төв" ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Р.Машбатыг томилсон байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын дотоод хяналтын талаар:

ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн "Хяналт шалгалт зохион байгуулах тухай 04 дүгээр тогтоолоор тус худалдааны төвийн санхүүгийн тайланд 2023 онд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хийсэн шалгалтыг үргэлжлүүлж, үлдсэн лангуу түрээслэгчдийн сар бүрийн түрээсийн төлбөрт тулгалт хийж, үр дүнг танилцуулахыг компанийн захиралд үүрэг болгосон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

"Шинэ мөрөн худалдааны төв" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна гэж үзлээ.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа "Шинэ мөрөн худалдааны төв" ХХК нь Нью-баланс аудит ХХК-тай 2023 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" боловсруулах 23/03/56 дугаартай гэрээг байгуулан ажилласан байна. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг байгууллагын нягтлан бодох бүртгэлд ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж гүйцэтгэх захирлын тушаалаар батлаагүй байна.

Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа НББОУС, СТОУС, Засгийн газар, Сангийн яам, удирдах бусад байгууллагаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад орсон өөрчлөлт

"Шинэ мөрөн худалдааны төв" ХХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн гол бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 161,677.9 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна.

Хүснэгт №-1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөгөөр/ Өөрчлөлт
	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	149,119.7	106,140.1	(42,979.6)
Авлага	65,946.2	41,432.4	(24,513.8)
Бараа материал	26,988.3	103,171.7	76,183.4
Үндсэн хөрөнгө	5,362,452.1	5,192,084.3	(170,367.8)
Биет бус хөрөнгө	104,050.0	104,050.0	-
Нийт хөрөнгө	5,708,556.4	5,544,030.9	(161,677.8)
Өр төлбөр	25,374.9	40,193.7	14,818.8
Эздийн өмчийн дүн	5,468,800.0	5,468,800.0	-
Эздийн өмчийн бусад хэсэг	804,442.7	804,442.7	-
Хуримтлагдсан ашиг	(590,061.1)	(766,557.8)	(176,496.7)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	5,708,556.4	5,544,030.9	(161,677.8)

Хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө 42,979.6 мянган төгрөгөөр, авлага 24,513.8 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгө 170,367.8 мянган төгрөгөөр тус тус буурч, бараа материал 76,183.4

мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд банкин дахь мөнгөн хөрөнгө 106,140.1 мянган төгрөг байна.

Бараа материалын дансанд 141,778.3 мянган төгрөгийн материалыг худалдан авч, 65,721.0 мянган төгрөгийн материалыг зарцуулж, үлдэгдлээр байгаа бараа материал нь тус байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдахгүй бэлтгэсэн хөрөнгө нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансанд 25,678.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, тээврийн хэрэгсэл дансанд худалдан авсан 19,600.0 мянган төгрөгийн суудлын автомашиныг ИТХ-ын даргын А/83 дугаартай захирамжаар аймгийн ИТХ-ын ажлын албанд шилжүүлж, 3,448.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталсан, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 175,844.7 мянган төгрөгөөр тооцсонтой холбоотой байна.

1.Илрүүлэлт:

Бараа материалын үлдэгдлийг биечлэн тооллого хийхэд 5 нэр төрлийн 82,630.0 мянган төгрөгийн бараа материал нь биетээр агуулахад байхгүй байна. Энэ нь *Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2. "Байгууллагын нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материал, үнэ бүхий зүйлийн тооллогоор бэлэн байсан үлдэгдэл, гарсан зөрүүг тооллогын акт материал батлагдсанаас хойш 5 хоногийн дотор нягтлан бодох бүртгэлд тусгаж дансны үлдэгдлийг тулган шалгана."* Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т *"комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх"* гэсэн *"Иж бүрэн байх"* батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Илрүүлэлт 2:

Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 16 нэр төрлийн 38,943.2 мянган төгрөгийн дансны үнийг шинэчлэн тогтоогоогүй байна Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан *"Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"*-ын 7 дугаар зүйлийн 7.1 *"Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ"* гэсэнтэй нийцэхгүй байгаа бөгөөд *"Үнэлгээ ба хуваарилалт"* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

3.5.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Гүйцэтгэх захирал нь үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө /техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн ээлжит бус XXIV хуралдааны 13 дугаарыг тогтоолыг үндэслэн ТУЗ-ийн 2024 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор компанийн 2024 оны бизнес төлөвлөгөөг баталсан байна.

Тайлант оны нийт орлогыг 642,690.0 мянган төгрөгөөр, нийт зардлыг 812,200.4 мянган төгрөг, 233,780.0 мянган төгрөгийн алдагдалтай баталсан байна.

Шинэ мөрөн худалдаан төв ХХК-ийн 2024 оны Зорилтот түвшин төлөвлөгөө, гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт №-2.

Мянган төгрөгөөр

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	хувь
I	Нийт борлуулалтын орлого	578,421,000.00	597,439,526.32	(19,018,526.32)	103%
1	Худалдааны төвийн орлого	549,171,000.00	569,006,674.22	(19,835,674.32)	103%
2	50*100* Цогцолборын орлого	12,800,000.00	10,788,988.00	2,011,012.00	84%
3	Соёмбо Цогцолборын орлого	6,450,000.00	6,875,000.00	(425,000.00)	107%
4	Бусад орлого	10,000,000.00	10,768,864.00	(768,864.00)	108%
II	Нийт үйл ажиллагааны зардал	812,200,400.00	753,735,028.03	58,465,371.97	93%
	Үйл ажиллагааны бус зардал		(20,201,250.00)	(20,201,250.00)	
	Үндсэн хөрөнгө данснаас хассан олз (гарз)		(20,201,250.00)	(20,201,250.00)	
	Татварын өмнөх ашиг/алдагдал	(233,779,400.00)	(176,496,751.71)		

Тайлант онд нийт 597,439.5 мянган төгрөгийн орлого олж 773,936.3 мянган төгрөгийн зардал гаргаж 176,496.7 мянган төгрөгийн алдагдалтай байна.

3.5.2 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Нийт орлогыг 578,421.0 мянган төгрөгөөр төлөвлөснөөс 597,439.5 мянган төгрөг буюу 3,2 хувиар давсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 773,936.3 мянган төгрөг болж, төлөвлөлтөөс 38,264.1 мянган төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байна. Энэ нь үйл ажиллагааны зардлыг 753,735.0 мянган төгрөгөөр, үйл ажиллагааны бус зардлыг 20,201.2 мянган төгрөгөөр зарцуулсан байна.

Илрүүлэлт 1:

ТУЗ-ын 01 дүгээр тогтоолоор 2024 оны бизнес төлөвлөгөөг 233,780.0 мянган төгрөгөөр алдагдалтай баталсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасан заалттай нийцээгүй, 21 дүгээр зүйлийн 21.4.2 "төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Хувьцаа эзэмшигчийн оруулсан оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ" гэсэн заалттай нийцээгүй "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

Илрүүлэлт 2: Хөрөнгө оруулалтаар хөрөнгө бэлтгэхээр бизнес төлөвлөгөөнд тусгаагүй, ИТХ-ын шийдвэрээр 19,600.0 мянган төгрөгийн суудлын автомашин худалдан авч ИТХ-ын албан хэрэгцээнд балансаас балансад шилжүүлсэн байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйл Хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим 4.1.7 бодитой байх, 6 дугаар зүйлийн 6.2 "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан зорилтот түвшнийг баримтлан ажиллах зөвлөмж өгөх

Илрүүлэлт 3: ТУЗ-ийн баталсан бизнес төлөвлөгөөнд батлагдсан тэтгэмжийн зардлыг 50,210.0 мянган төгрөгөөр хэтрүүлж, гүйцэтгэх захирлын тушаалаар 6 албан хаагчдад 19,639.2 мянган төгрөгийн тэтгэмж олгохдоо хууль эрх зүйг зөрчиж нотлох баримтыг хангалттай бүрдүүлж ажиллаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Хөдөлмөрийн дотоод журмын 9.1.4, 9.1.5, 9.1.6 гэсэн заалтуудтай нийцэхгүй Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, таслан зогсоох албан шаардлага өгөх.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

2024 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн худалдааны төв нь тайлант онд 39 нэр төрлийн 4,392.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй бараа ажил үйлчилгээг худалдан авсан байна.

Хүснэгт №-4.

Мөрдсөн журам	Төлөвлөсөн	Гэрээ байгуулсан	Төсөвт өртөг /мян.төг/	Гэрээ байгуулсан дүн /мян.төг/
Шууд худалдан авалт		6	123,870.00	123,130.0
Байр ашиглалтын зардал		2	59,620.0	48,761.3
Тохижилтын ажилд		1	25,000.0	12,000.0
Нийт	-	9	208,490.0	183,891.3

ТУЗ-ийн тогтоолоор 2024 оны 03 дугаар 21-ны 05 дугаар тогтоолоор 112,870.0 мянган төгрөг, 2024 оны 05 дугаар сарын 03-ны 15 дугаар тогтоолоор 25,000.0 мянган төгрөг, мөн оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 20 дугаар тогтоолоор 11,000.0 мянган төгрөг нийт 148,870.0 мянган төгрөгийг бизнес төлөвлөгөөнд өөрчлөлт оруулалгүй зардлыг нэмэгдүүлсэн байна. Ус суваг ХХК-тай бохир ус зайлуулах гэрээг 22,820.0 мянган төгрөг, Могойн гол ХХК-тай Нүүрс нийлүүлэх гэрээг 184 тонн нүүрсийг 36,800.0 мянган төгрөгөөр нийлүүлэх гэрээг байгуулж ажилласан байна.

АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хөвсгөл аймгийн "Шинэ мөрөн худалдааны төв" ОНӨҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн компанийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг "Гурван хөх морьт аудит" ХХК-ийн туслах аудитор Б.Баттуяа, аудитор Ш.Саранчимэг, нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг гүйцэтгэх захирал Н.Отгончимэг хэрэгжүүлж, төрийн аудитын байгууллагаас хоёр дахь шатны хяналтыг аудитор Л.Мандахнаран, аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөвсгөл аймгийн "Шинэ мөрөн худалдааны төв" ОНӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланг Гурван хөх морьт аудит ХХК-д 2024 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 19 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 699,944.1 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,499.0 мянган төгрөгөөр, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7,784.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд горим сорил хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй асуудал илэрлээ. Үүнд:

Илрүүлэлт 1: Шинэ жилийн үйл ажиллагаанд зориулж 2,500.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан. Дээрх зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "үр ашигтай байх" 12 дугаар зүйлийн 12.1.4. "хуулиар зөвшөөрөөгүй бусад" 15 дугаар зүйлийн 15.1.5. "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15 дугаар зүйлийн 15.1.7. "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах"-ыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын төсвөөс үр ашиггүй зардал гаргасан тул 2,500.0 төгрөгийн төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний талаар:

"Шинэ мөрөн худалдааны төв" ОНӨҮГ-ын гүйцэтгэх захирал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн даргатай 2023 оны 03 дугаар сарын 22-ны өдөр онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулсан байна. Гэрээгээр гүйцэтгэх захирал нь компанийн хувьцаа эзэмшигчдийн эд хөрөнгө үр ашигтай эзэмшин, ашиглаж, захиран зарцуулах, компанийн үйлдвэрлэл, үйлчилгээ борлуулалтын үр ашгийг дээшлүүлэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбогдон үүсэх талуудын харилцааг зохицуулах эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлоход гэрээний зорилго оршино. Тухайн гэрээний хэрэгжилтэй холбоотой дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

Илрүүлэлт 2:

ТУЗ-н 14 дүгээр тогтоолоор компанийн гүйцэтгэх удирдлагын багт 14,256.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгохдоо гэрээний үүргийн хэрэгжилтийг бодитой дүгнээгүй, түүнд заасан шаардлагыг хангаагүй байхад урамшуулал олгох шийдвэр гаргасан байна. Энэ нь ТУЗ-ын гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 4.3.1-д "гэрээний хавсралтаар баталсан санхүү, үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлтүүдийн зорилтод түвшин, гэрээний үүргийн биелэлт 100 хувийн биелэлттэй хэрэгжсэн тохиолдолд компанийн тухайн жилийн норматив цэвэр ашгаас давсан цэвэр ашгийн 10 хувь хүртэл хувийг гүйцэтгэх захирлын удирдлагын багт жилд нэг удаа олгоно" гэж заасан заалттай нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Илрүүлэлт 3:

ТУЗ-ийн 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 18 дугаар тогтоолоор албан тушаалаас чөлөөлөгдсөн компанийн гүйцэтгэх захиралд 14,256.0 мянган төгрөгийн тэтгэмжийг нотлох баримтгүй, хууль эрх зүй үндэслэлгүй олгосон байна. Дээрх зөрчил нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80.1.3-т "ажилтан эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй нь эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоогдсон бөгөөд түүнийг шилжүүлэн ажиллуулах өөр ажлын байр байхгүй" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4,000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт:

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 2,000.0 мянган төгрөгөөр дутуу 1 мэдээлэл, орлогын гүйлгээнээс 6,700.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг оруулаагүй мөн нийт оруулбал зохих 178 мэдээллээс 8 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Тайланд төлөвлөгөөний гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбар оруулж хэвшээгүй, холбогдох тушаал шийдвэрийг хавсралт файлаар оруулдаггүй байна. Аудитын явцад алдааг залруулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

"Шинэ мөрөн худалдааны төв" ОНӨҮГ-ын 2024 оны санхүүгийн тайлангийн аудитаар хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд дараах зөрчилтэй асуудлууд илэрлээ.

Илрүүлэлт 1: Аймгийн ИТХ, ТУЗ-ын шийдвэрээр тухайн байгууллагын харилцах дансны үлдэгдлээс 123,870.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэж, улсын төсвийн байгууллагууд, ахмадын хороодод үнэ төлбөргүй өгсөн дээд шатны байгууллага нь гүйцэтгэх удирдлагын эрхэнд халдсан, тухайн байгууллагын үр ашгийг бууруулсан үйлдэл болсон байна Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д "Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар хийсэн ажил, үр дүнгийн талаар товч бичнэ. Хэрвээ асуудлын бүртгэлээр зөвлөмж өгсөн бол биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянаж үр дүнг аудитын тайланд тусгана. Биелэлт хангалтгүй бол тайлант оны буруу илэрхийллийн дүнд оруулна.

Завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитыг 2023 оны 3 дугаар улирлын байдлаарх санхүүгийн баримт материал, бүртгэл тайлагналыг хамруулан гүйцэтгэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 80.0 мянган төгрөгийн 5 зөвлөмж, нийцлийн аудитаар худалдан авах ажиллагаатай холбоотой 33,500.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжийг өгсөн байна.

Хүснэгт 5. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/				
	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	6	36,580.0	6	36,580.0	100.0
Нийт дүн	6	36,580.0	6	36,580.0	100.0

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж биелэлтийг гаргасан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

"Шинэ мөрөн худалдааны төв" ОНӨҮГ-ын бизнес төлөвлөгөөнд үр ашгийг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулан хэрэгжүүлэн ажилласан эсэх асуудлыг дараагийн аудитаар анхаарал хандуулах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32,103.8 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 541,102.0 мянган төгрөгийн зөрчил илэрснээс, 16,756.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 290,566.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, таслан зогсоох 5 албан шаардлага хүргүүлж, 233,780.0 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Аудитын залруулга:

1. Гэрэл цахилгааны 29,789.9 мянган төгрөгийн авлагыг тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрсөн;
2. Сахилгын арга хэмжээний 438.7 мянган төгрөгийн суутгалыг бусад орлогоор хүлээн зөвшөөрсөн;
3. Бохир ус зайлуулах 1,875.2 мянган төгрөгийг дулааны зардалд бүртгэсэн алдааг залруулсан.
4. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээнээс 2,000.0 мянган төгрөгөөр дутуу 1 мэдээлэл, орлогын гүйлгээнээс 6,700.0 мянган төгрөгийн 1 мэдээллийг оруулаагүй мөн нийт оруулбал зохих 178 мэдээллээс 8 мэдээлэл хугацаа хоцроосон байна. Тайланд төлөвлөгөөний гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан, тайлбар оруулж хэвшээгүй, холбогдох тушаал шийдвэрийг хавсралт файлаар оруулдаггүй байна. Аудитын явцад алдааг залруулсан байна.

5.1 Төлбөрийн акт

Аудитаар илэрсэн зөрчилд 2,500.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоосон. Үүнд:

1. Шинэ жилийн үйл ажиллагаанд зориулж 2,500.0 мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан. Дээрх зөрчил нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3. "үр ашигтай байх" 12 дугаар зүйлийн 12.1.4. "хуулиар зөвшөөрөөгүй бусад" 15 дугаар зүйлийн 15.1.5. "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", 15 дугаар зүйлийн 15.1.7. "байгууллагын төсвөөр согтууруулах ундаа худалдан авах"-ыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.
2. ТУЗ-ийн 2024 оны 11 дүгээр сарын 27-ны өдрийн 18 дугаар тогтоолоор албан тушаалаас чөлөөлөгдсөн компанийн гүйцэтгэх захиралд 14,256.0 мянган төгрөгийн тэтгэмжийг нотлох баримтгүй, хууль эрх зүй үндэслэлгүй олгосон байна. Дээрх зөрчил нь Хөдөлмөрийн тухай хуулийн 80.1.3-т "ажилтан эрүүл мэндийн хувьд ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй нь эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шийдвэрээр тогтоогдсон бөгөөд түүнийг шилжүүлэн ажиллуулах өөр ажлын байр байхгүй" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

1. Бараа материалын үлдэгдлийг биечлэн тооллого хийхэд 5 нэр төрлийн 82,630.0 мянган төгрөгийн бараа материал нь биетээр агуулахад байхгүй байна. Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д "Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2 "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1. жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; 20.2.6 эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн "Иж

бүрэн байх" батламж мэдэгдлийг хангаагүй байгаа тул зөрчлийг арилгах албан шаардлага тогтоов.

2. ТУЗ-ийн баталсан бизнес төлөвлөгөөнд батлагдсан тэтгэмжийн зардлыг 50,210.0 мянган төгрөгөөр хэтрүүлж, гүйцэтгэх захирлын тушаалаар 6 албан хаагчдад 19,639.2 мянган төгрөгийн тэтгэмж олгохдоо хууль эрх зүйг зөрчиж нотлох баримтыг хангалттай бүрдүүлж ажиллаагүй зөрчил илэрсэн. Энэ нь Хөдөлмөрийн дотоод журмын 9.1.4, 9.1.5, 9.1.6 гэсэн заалтуудтай нийцэхгүй Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлийг хангахгүй байгаа албан шаардлага хүргүүлсэн.

3. ИТХ-ын шийдвэрээр хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй 19,600.0 мянган төгрөгийн өртөгтэй суудлын автомашин худалдан авч аймгийн ИТХ-ын ажлын албаны албан хэрэгцээнд балансаас балансад шилжүүлсэн нь тухайн байгууллагын чиг үүрэгт хамааралгүй, төлөвлөгөөнд тусгагдаагүй хөрөнгө худалдан авсан зөрчил илэрсэн. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т "Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно" гэсэн заалт "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

4. ТУЗ-н 14 дүгээр тогтоолоор компанийн гүйцэтгэх удирдлагын багт 14,256.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгохдоо гэрээний үүргийн хэрэгжилтийг бодитой дүгнээгүй, түүнд заасан шаардлагыг хангаагүй байхад урамшуулал олгох шийдвэр гаргасан байна. Энэ нь ТУЗ-ын гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний 4.3.1-д "гэрээний хавсралтаар баталсан санхүү, үйл ажиллагаа, эдийн засгийн үзүүлэлтүүдийн зорилтод түвшин, гэрээний үүргийн биелэлт 100 хувийн биелэлттэй хэрэгжсэн тохиолдолд компанийн тухайн жилийн норматив цэвэр ашгаас давсан цэвэр ашгийн 10 хувь хүртэл хувийг гүйцэтгэх захирлын удирдлагын багт жилд нэг удаа олгоно" гэж заасан заалттай нийцэхгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5. Аймгийн ИТХ, ТУЗ-ын шийдвэрээр тухайн байгууллагын харилцах дансны үлдэгдлээс 123,870.0 мянган төгрөгөөр хөрөнгө бэлтгэж, улсын төсвийн байгууллагууд, ахмадын хороодод үнэ төлбөргүй өгсөн дээд шатны байгууллага нь гүйцэтгэх удирдлагын эрхэнд халдсан, тухайн байгууллагын үр ашгийг бууруулсан үйлдэл болсон байна Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3-д "Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын хөрөнгөөр хандив, тусламж, түүнтэй адилтгах аливаа хөтөлбөр, арга хэмжээ, нийгмийн шинжтэй үйл ажиллагаа болон төсвийн алдагдлыг санхүүжүүлэхийг хориглоно" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдэлийг хангахгүй байгаа тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.3.1 Бизнес төлөвлөгөөний төлөвлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

ТУЗ-ын 01 дүгээр тогтоолоор 2024 оны бизнес төлөвлөгөөг 233,780.0 мянган төгрөгөөр алдагдалтай баталсан байна. Энэ нь: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т заасан заалттай нийцээгүй, 21 дүгээр зүйлийн 21.4.2 "төрийн өмчийн төлөөллийг хэргжүүлж байгаа хуулийн этгээдийн эд хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах талаар санал боловсруулж төрийн өмчийн бодлого зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оруулах" Компанийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д "Хувьцаа эзэмшигчийн оруулсан оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ" гэсэн заалттай нийцээгүй "эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангаагүй.

Өгсөн зөвлөмж: Компанийн ашигтай ажиллахаар төлөвлөгөөг батлах

5.3.2 Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгийн үлдэгдэлд хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 16 нэр төрлийн 38,943.2 мянган төгрөгийн дансны үнийг шинэчлэн тогтоогоогүй байна Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэнтэй нийцэхгүй байгаа бөгөөд "Үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Зохиж журмыг мөрдөж үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгах

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5. "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу аудитаар илэрсэн зөрчлийг арилгаж ажиллах ажлын төлөвлөгөөг боловсруулан 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор, төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:			
					Залруулсан		Залруулаагүй	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Орлогыг 30,228.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, зардлыг буруу бүртгэсэн байна.	3	32,103.7	3	32,103.7	3	32,103.7		
Шилэн дансны мэдээлэл 8,700.0 мянган төгрөгийн алдааг залруулсан	1	8,700.0			1	8,700.0		
Дүн	4	40,803.7	3	32,103.7	4	40,803.7		

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үр ашиггүй зардал гаргасан	1	2,500.0	1	2,500.0				
Тэтгэмж илүү олгосон	1	14,256.0	1	14,256.0				
Тооллогоор хөрөнгө дутуу	1	82,630.0			1	82,630.0		
Зардал илүү зарцуулсан	1	50,210.0			1	50,210.0		
ТУЗ-ын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй хөрөнгө бэлтгэсэн	1	19,600.0			1	19,600.0		

Хөвсгөл аймгийн "Шинэ мөрөн худалдааны төв" ХХК-ийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Гэрээний үүргийн хэрэгжилтийг бодиттой дүгнээгүй	1	14,256.0			1	14,256.0		
ТУЗ гүйцэтгэх удирдлагын эрхэнд халдсан, тухайн байгууллагын үр ашгийг бууруулсан	1	123,870.0			1	123,870.0		
Бизнес төлөвлөгөөг алдагдалтай төсөвлөсөн	1	233,780.0					1	233,780.0
Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгаагүй	1	-					1	-
Дүн	9	541,102.0	2	16,756.0	5	290,566.0	2	233,780.0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Шилэн дансны хууль хэрэгжүүлээгүй								
Дүн								